## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БУЛГАН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/148/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn<br>Тунгалаг бүртгэл аудит ХХК<br>Аудитор: Ч.Мөнхцоoз<br>Цахим хаяг: Auit.munhuu@yahoo.com<br>Утас: 99028555 |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....
3. Аудитын тайлан ..... 3
3.1. Ерөнхий зүйл ..... 8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 9
3.4. Материаллаг байдал ..... 9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 11
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12
3.9. Аудитын илрүүлэлт ..... 12
Залруулсан алдаа ..... 12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 12
Аудитын зөвлөмж .....
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 12
4. Менежментийн захидал ..... 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 13

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/128
танай ____________ -ны № ____________ -т

БУЛГАН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.МӨНХДАЛАЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Булган сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ард иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, үндэсний язгуур өв соёлоо түгээн дэлгэрүүлэх ажлын хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 3.Аудитын тайлан

# 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,365,971.00** | **16,205,599.00** |
| **33** | **АВЛАГА** | 5,017,772.00 | 5,000,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,017,772.00 | 5,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,348,199.00 | 11,205,599.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 8,348,199.00 | 11,205,599.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,035,000.00 | 1,035,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,413,199.00 | 7,515,599.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,900,000.00 | 2,655,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **650,638,579.84** | **645,179,012.07** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 650,638,579.84 | 645,179,012.07 |
| **392** | **Биет хөрөнгө** | 643,318,579.84 | 637,859,012.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 609,129,850.00 | 609,129,850.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -10,152,164.16 | -20,304,328.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,885,505.00 | 28,039,505.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,963,245.00 | -24,662,560.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,099,020.60 | 57,282,020.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -31,381,331.60 | -36,326,420.21 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 2,340,600.00 | 2,340,600.00 |
| 39217 | Ном | 22,360,345.00 | 22,360,345.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,320,000.00 | 7,320,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,320,000.00 | 7,320,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **664,004,550.84** | **661,384,611.07** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **664,004,550.84** | **661,384,611.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 664,004,550.84 | 661,384,611.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 273,915,436.00 | 273,915,436.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 273,915,436.00 | 273,915,436.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -125,350,029.16 | -127,969,968.93 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -125,350,029.16 | -125,350,029.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -2,619,939.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 515,439,144.00 | 515,439,144.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **664,004,550.84** | **661,384,611.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **38,712,900.00** | **120,136,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,418,500.00** | **14,050,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,418,500.00 | 14,050,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,418,500.00 | 14,050,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,418,500.00 | 4,050,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 10,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **106,086,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 37,294,400.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 3,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 103,086,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 103,086,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **21,367,497.33** | **122,756,739.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,367,497.33** | **122,756,739.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 21,367,497.33 | 117,166,884.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 15,558,453.00 | 70,663,201.20 |
| 210101 | Үндсэн цалин | 15,558,453.00 | 70,663,201.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,944,807.00 | 9,232,710.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,944,807.00 | 9,232,710.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 18,100,953.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 1,868,953.00 |
| 210302 | Түлш, халаалт | - | 16,232,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 2,379,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 2,368,220.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 10,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 265,700.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 265,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 90,000.00 | 728,732.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 628,732.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,774,237.33 | 15,796,567.77 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,774,237.33 | 15,796,567.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 5,589,855.24 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 2,589,855.24 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,589,855.24 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **17,345,402.67** | **(2,619,939.77)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **17,345,402.67** | **(2,619,939.77)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **49,036,700.00** | **110,136,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,418,500.00** | **4,050,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,418,500.00 | 4,050,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,418,500.00 | 4,050,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,418,500.00 | 4,050,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **47,618,200.00** | **106,086,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 47,618,200.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 3,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 103,086,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 103,086,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **45,578,035.00** | **110,136,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **45,578,035.00** | **110,136,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **45,578,035.00** | **104,546,944.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 31,752,334.00 | 69,462,915.20 |
| 210101 | Үндсэн цалин | 20,448,656.00 | 66,304,673.20 |
| 210102 | Нэмэгдэл | 2,098,583.00 | 3,158,242.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,205,095.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,876,201.00 | 10,415,224.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,876,201.00 | 10,415,224.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,050,000.00 | 17,855,953.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 1,868,953.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,000,000.00 | 15,987,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 604,300.00 | 1,838,920.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 604,300.00 | 1,718,220.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 120,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 152,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 152,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,295,200.00 | 4,821,932.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,205,200.00 | 4,721,932.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **5,589,855.24** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,589,855.24 |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,589,855.24 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,000,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,458,665.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 3,458,665.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 3,458,665.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 266,595,436.00 | 125,942,544.00 | -112,572,208.60 | 00.00 | 279,965,771.40 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **266,595,436.00** | **125,942,544.00** | **-112,572,208.60** | **00.00** | 279,965,771.40 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 7,320,000.00 | 00.00 | -9,221,484.28 | 00.00 | -1,901,484.28 |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **273,915,436.00** | **500,041,534.00** | **-125,350,029.16** | **00.00** | 648,606,940.84 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **273,915,436.00** | **500,041,534.00** | **-125,350,029.16** | **00.00** | 648,606,940.84 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **273,915,436.00** | **500,041,534.00** | **-125,350,029.16** | **00.00** | 648,606,940.84 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -2,619,939.77 | 00.00 | -2,619,939.77 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **273,915,436.00** | **500,041,534.00** | **-127,969,968.93** | **00.00** | 645,987,001.07 |

## 2.4 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

**2:5 Нэмэлт санхүүжилтийн тайлан гараагүй**

## 3.1. Ерөнхий зүйл

Булган сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Мөнхдалай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эд хариуцагчийн тайлан, тооллого тооцоог баталгаажуулах, баримтын бүрдлийг хангаж ажиллах, орлогыг үнэн зөв бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 2 дугаар сарын 10 -наас 2021 оны 2 дугаар сарын 15–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагатай гэрээ байгуулж Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцоош хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

*Булган сумын Соёлын төв нь “угсаатны өвөрмөц өв соёлыг сурталчлан өвлүүлэн түгээх, хайрлан хамгаалах, үйлчлүүлэгчдийн оюуны эрэлт хэрэгцээг бүрэн хангасан шинэлэг урлаг соёлын үзвэр үйлчилгээ, номын сан музей, биет болон биет бус өвийг хөгжүүлэх ” гэсэн зорилго дэвшүүлжээ.*

*Төр засгийн болоод аймаг орон нутгийн соёл урлагын бодлого хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлж ёс зүй харилцаа, хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэн үйлчилгээний орчинг сайжруулан ажиллах зорилт тавин ажилласан байна.*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тус байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагад 2020 онд аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлангийн нийт зарлага 122756,7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1227,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо. Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын соёлын төвийн нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2619.9 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 5,017,772 | 5,000,000 | -17,772 |
| Бараа материал | 8,348,199 | 11,205,599 | 2,857,400 |
| Үндсэн хөрөнгө | 650,638,579 | 645,179,012 | -5,459,567 |
| **Нийт хөрөнгө** | **664,004,550** | **661,384,611** | **-2,619,939** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 664,004,550 | 661,384,611 | -2,619,939 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **664,004,550** | **661,384,611** | **-2,619,939** |

Бараа материал дансны үлдэгдэл материаллаг дүнгээр өсөхөд аж ахуйн материалын үлдэгдэл өссөн нь нөлөөлжээ.

Булган сумын Соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 5459,5 мянган төгрөгөөр буюу буурсан байна. Үүнд тайлан оны хуримтлагдсан элэгдлийн дүн ихээхэн нөлөөлж байгаа боловч Булган сумын ОНХсангаас сумын номын санг тохижуулах 10000,0 мянган төгрөгийн ажил хийснээр ширээ, номын тавиур мэтийн эд хогшил шинээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 264,690 | 930,274 | 665,585 |
| Бараа материал | 150,000 | 1,830,000 | 1,680,000 |
| Үндсэн хөрөнгө | 70,664,981 | 1,269,272,187 | 1,198,607,206 |
| **Нийт хөрөнгө** | **71,079,671** | **1,272,032,462** | 1,200,952,791 |
| Өр төлбөр | 27996 | 54688.4 | 26,692 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 71,051,675 | 1,271,977,773 | 1,200,926,099 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **71,079,671** | **1,272,032,462** | **1,200,952,791** |

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1205860,4 мянган төгрөгөөр хувиар өссөн байна. Төсвийн санхүүжилт данс 8398,9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотой байна

Үнэ төлбөргүй хөрөнгийн орлого улс орон нутгийн төсөв, тусгай сангийн хөрөнгөөр бэлтгэн ашиглалтад хүлээн авсан хөрөнгийн дүнгээр өссөн байна.

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Төсвөөс олгосон санхүүжилт | 37,294,400 | 103,086,800 | 65,792,400 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө | | 10,000,000 | 10,000,000 |
| өөрийн орлого | 1,418,500 | 4,050,000 | 2,631,500 |
| бусад санхүүжилт | | 3,000,000 | 3,000,000 |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **38,712,900** | **120,136,800** | **81,423,900** |

Тайлант жилд санхүүгийн дэмжлэгээр 104421,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас, гүйцэтгэлээр 103086,8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үүнээсээ 2589,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлогын 4000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгөөс, гүйцэтгэлээр 4050,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Сумын ОНХС-аас 10000,0, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3000,0 бүгд 13 сая төгрөгийг соёлын төв, номын сангийн тохижуулалтанд зориулан олгосон боловч цаг үеийн байдлаас хамаарч ажил бүрэн хийгдээгүйгээс 3000,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тайлант жилд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй байна.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 108421,0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 104421,0 мянган төгрөгийн төсөв батласнаас 103086,8 мянган төгрөгийг олгожээ.

Гүйцэтгэлээр төсвөөс 103086,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 4050,0 мянган төгрөг, нийт 107086,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 104505,0 мянган төгрөгийг зарцуулж 2581,5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ | 33,628,535 | 79,878,140 | 46,249,605 |
| Байр ашиглалттай холбоотой зардал | 8,050,000 | 17,855,953 | 9,805,953 |
| Хангамж бараа материалын зардал | 604,300 | 1,838,920 | 1,234,620 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 6,753,865 | 4,973,932 | (1,779,933) |
| бусад урсгал шилжүүлэг | | 5,589,855 | 5,589,855 |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **49,036,700** | **110,136,800** | **61,100,100** |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 61100,0 мянган төгрөг буюу 124 хувиар өссөн нь цалин шимтгэлийн зардал 46249,6 мянган төгрөгөөр өсөж, бараа үйлчилгээний бусад зардлууд 14850,4 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн нэмэгдэх өөрчлөлт хийгдсэн болон тогтмол зардлын дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд ямар нэгэн нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуульд заасан мэдээллийг цаг тухайд нь мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 чиглэлийн 5468,5 мянган төгрөгийн авлага, орлого төвлөрүүлэл, бүртгэл хөтлөлттэй холбоотой зөвлөмж өгч уг зөвлөмж тодорхой түвшинд хэрэгжсэн боловч шууд үр дүнг харьцуулах бүрэн хэрэгжсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн материаллаг алдаа илрээгүй бөгөөд 2 төрлийн зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Байхгүй

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн илрээгүй.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Анхан шатны баримтын бүртгэл**

*2.1.* ***Илрүүлэлт:*** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

***2.2 Эрсдэл*:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3 ***Өгсөн зөвлөмж:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4 ***Байгууллагаас өгсөн хариу тайлбар***: Асуудлын бүртгэлээр нягтлан бодогчид танилцуулж гарын үсэг зуруулсан.

**Өөрийн орлого бүрдүүлэлт**

**3.1. Илрүүлэлт :** Тайлант жилд өөрийн орлогоор 1,0 сая төгрөг бүрдүүлэхээс 900,0 мянган төгрөгийг хандивын орлогоос, 100,0 мянган төгрөгийг байрны түрээсийн орлогоор бүрдүүлсэн нь өөрийн орлого бүрдүүлэлтийн шаардлага хангахгүй байна.

3.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан дахь орлого буруу тооцогдох төлөвлөлтөд сөрөг нөлөө үзүүлэх

3.3. Өгсөн зөвлөмж : Төлбөртэй үйлчилгээний орлого болон үйл ажиллагааны бодит үр дүнгээр олсон орлогоос өөрийн орлогыг бүрдүүлэх, орлогын нөөцийг судлан зөв бүртгж зөв тайлагнах
3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

**/ Мянган төгрөгөөр/**

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн/ мян.төг/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалин илүү тооцсон | 47.2 | Зөвлөмж | соёлын төвийн эрхлэгч | Д.Мөнхдалай |
| 2 | Зарим анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй | | Зөвлөмж | соёлын төвийн эрхлэгч | Д.Мөнхдалай |
| | НИЙТ | 47.2 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**